



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.03 № 03/10238
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг 2014 оны 09 дүгээр сарын 10-наас 2014 оны 09 дугаар сарын 17-ны өдрүүдэд Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Ажлын алба болон Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцлаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон Хурлын 2013, 2014 онуудын тогтоол, тэмдэглэл, Хурлын даргын захирамж, ирсэн, явсан бичгийн бүртгэл, албан бичгүүдтэй танилцах явцад авлигын эсрэг хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн байна. Үүнд:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2013 оны 51 дүгээр захирамжаар дүүргийн Хурлын төлөөлөгч Х.Өлзийтогтохыг орон сууцаар шагнагдсан явдалд хүндэтгэл үзүүлэхэд 150 000 төгрөгийн, 2013 оны 388 дугаар захирамжаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгч Э.Содгэрэл захиралтай “Гурван тамир” бүрэн дунд сургуулийн 15 жилийн ойн баярт хүндэтгэл үзүүлж 683 600 төгрөгийн, 2013 оны 108 дугаар захирамжаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан 1 400 000 төгрөгийг тус тус төвлөрсөн төсөл арга хэмжээ, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлуудаас гаргаж шийдвэрлэсэн байна.

Уг шийдвэрүүдийг гаргахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2/01 дүгээр тогтоолуудыг баримталсан нь дүүрэгт баталсан төсвийн зарцуулалтаас тухайн зардлыг гаргах үндэслэл гэж үзэх боломжгүй бөгөөд энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалтыг;

2. Хурлын даргын 2014 оны 242 дугаар захирамжаар Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 11 495 000 төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардлаас гарган зөвхөн хоол, хүнсний зориулалтаар зарцуулсан нь Засгийн газрын 2010 оны 172 дугаар

“Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам” тогтоолын хавсралтаар баталсан “Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх”-ын 5.3 дахь хэсгийн заалттай нийцээгүй байх бөгөөд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан;

3. ИТХ-ын даргын 2013 оны захирамжаар БНСУ-ын Сөүл хотод туршлага судлах уулзалтад оролцох зардалд 2 996 400 төгрөгийг, 2013 оны 341 дүгээр захирамжаар дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг БНХАУ-д туршлага судлах зорилгоор томилолтоор ажиллахад 54 668 700 төгрөгийг /өөрийн нэрийг оруулан/ тус тус шийдвэрлэсэн байх бөгөөд дээрхи шийдвэрүүдийг гаргахдаа үндэслэл болгосон иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар дээрхи асуудлууд огт хэлэлцэгдээгүй байх ба энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг зөрчсөн шийдвэр болсон байна.

4. Иргэдийн Төлөөлөгчдын хурлын дарга Д.Дэлгэрбат нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Хууль зүйн сайд, сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтанд олгогдсон эрхийг эдлэн Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хангах талаар 2013 онд явуулсан үйл ажиллагааны үр дүнг харгалзан салбар зөвлөлийн дарга /өөртөө/ -д 800 000 төгрөг, мөн дэд дарга бөгөөд Засаг даргад 800 000 төгрөг, нарийн бичгийн 2 дарга тус бүрт 500 000 төгрөг, нягтлан бодогчид 500 000 төгрөг, нийт 3 100 000 төгрөгийн урамшууллыг ИТХ-ын даргын 2013 оны 428 дугаар захирамжаар олгосон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-д зааснаар Зөвлөлийн гишүүн болон дарга зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавихтай холбогдсон асуудлаар л захирамж гаргах эрхтэй байхаар заажээ.

7. ИТХ-ын 2013 оны 75 дугаар тогтоолоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Дэлгэрбат нь өөрийнхөө хагас жилийн ажлын үр дүнг харгалзан нэг сарын үндсэн цалинтай, 2013 оны 111 дүгээр тогтоолоор хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний, 2014 оны 266 дугаар захирамжаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын улирлын урамшуулалд өөртөө цалингийн 40 хувиар мөнгөн урамшууллыг тус тус олгохоор шийдвэрлэсэн тогтоол, захирамжид гарын үсэг зурж баталгаажуулсан байх ба дээрх тогтоол гаргасан өдрийн хуралдаануудаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэмдэглэлд тусгагдаагүй байгаа нь уг асуудлыг хэлэлцээгүй гэж байна.

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Дэлгэрбатын дээрх үйлдлүүд нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, 7.1.7 болон Нийтийн

албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтууд, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “За Суваг TV” болон ETV – суваг телевизтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд “За Суваг TV” нь тус дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгч Э.Ганболор, Э.Содгэрэл нарын дүү Э.Одбаярын үүсгэн байгуулсан суваг болох нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар тогтоогдсон бөгөөд энэхүү гэрээг иргэд олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай шийдвэр болсон байна.

Мөн дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгч Н.Нинжбадгар, төлөөлөгч Э.Содгэрэл, Э.Содгэрэлийн нөхөр Хурлын төлөөлөгч Г.Энхболд болон Хурлын төлөөлөгч Э.Ганболор нар нь хамаарал бүхий этгээд байх бөгөөд Э.Содгэрэл нь “Гурван тамир” төрийн өмчит сургуулийн захирлаар ажилладаг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Дүүргийн 2013 оны төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай асуудлын хүрээнд тус сургуулийн 2013 оны төсвийг шийдвэрлэхэд Хурлын Төлөөлөгч Э.Ганболор, Н.Нинжбадгар, Г.Энхболд нар, Дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай асуудлын хүрээнд Хурлын Төлөөлөгч Г.Энхболд, Э.Ганболор болон “Гурван тамир” сургуулийн багш, төлөөлөгч Т.Төгөлдөр нар саналын эрхтэйгээр оролцсон байна. 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Дүүргийн 2014 оны төсөв батлах хүрээнд Хурлын Төлөөлөгч Э.Ганболор, Н.Нинжбадгар нар, 2014 оны төсвийг батлах явцад оролцсон байх бөгөөд энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах үүргээ хэрэгжүүлэлгүйгээр ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан гэж үзэхээр байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу /Эрх бүхий албан тушаалтан /-д үүрэгжүүлсэн бүртгэл хөтлөлтөд ИТХ-ын дарга болон дээрх Хурлын Төлөөлөгчдөөс өөрийн ашиг сонирхлыг хөндсөн удаа дараагийн болон иргэд олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай шийдвэрүүдийг гаргахдаа ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн тухай бүртгэгдээгүй байна.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс 2014 оны 25 дугаар тогтоолоор дүүрэг байгуулагдсаны 50 жилийн ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөв болон иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хандиваар санхүүжүүлэх, хандивын орлогыг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журмыг баталжээ.


Дээрх шийдвэрийг гаргахдаа Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 3.3 дахь заалтыг үндэслэсэн байх байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2012 оны 5 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийн 16, 17 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн Засгийн газрын 2012 оны 109 дүгээр тогтоолын 1-д “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдөр, тодорхой салбар, байгууллагын ой, зарим ажил, мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөнгөн шагналаар урамшуулахаар хүсэлт гаргах, хандив, бэлэг, бусад санхүүгийн туслалцаа авах асуудлыг таслан зогсоохыг төсвийн захирагч нарт даалгасугай.” гэж заасныг илтэд зөрчсөн байна.

Түүнчлэн Хог хаягдлын тухай хуулиар Засгийн газраас тогтоосон аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох бүрэн эрх аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байтал дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс 2013 оны 30 дугаар тогтоолоор “Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”-г тогтоосон нь Тэргүүлэгчдэд хуулиар олгогдоогүй чиг үүргийг хэрэгжүүлжээ.

Иймд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 –ийн “ж” хэсгийг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар “Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ тогтоох тухай ” тогтоол, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн 2014 оны 25 дугаар “ ... хандиваар санхүүжүүлэх, хандивын орлогыг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журам”- ыг хянан үзэж хуульд нийцүүлэх, хүчингүй болгох талаар холбогдох арга хэмжээг авна уу.

Цаашид Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурьдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллахыг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтын дагуу Зөвлөмж болгож байна.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ